

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУГАЦААТ ТАЙЛАГНАЛ БОЛОН ТУХАЙ БҮР МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА, ХЭЛБЭР

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Хороо, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь энэ журамд заасан мэдээллийг доорх зааварт заасан маягтын дагуу бэлтгэж, Хороонд ирүүлэх бөгөөд тухайн мэдээллийг өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

1.2. Хороо нь үнэт цаас гаргагчаас хугацаат тайлагнал болон тухай бүх мэдээлэх мэдээллийг шаардлагатай тохиолдолд олон нийтэд мэдээлэх ажлыг өөрийн цахим хуудсаар дамжуулан зохион байгуулна.

1.3. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчээс үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл нь алдаатай эсхүл эргэлзээтэй гэж үзвэл Хороонд холбогдох нотлох баримтыг хавсарган гомдол гаргах эрхтэй бөгөөд Хорооноос гомдлыг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн шинжээч томилон хяналт шалгалт хийнэ.

1.4. Үнэт цаас гаргагч нь энэ журамд заасан мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд мэдээлэх үүрэгтэй бөгөөд худал, ташаа мэдээлэл ирүүлсэн тохиолдолд Хорооны хянан шалгагчаас Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхийг АНХААРНА УУ!!!

ХОЁР. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилийн тайлагналын мэдээллийн агуулга

2.1. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилийн үйл ажиллагааны тайлагналын мэдээлэл нь доорх 9 төрлийн цогц мэдээллээс бүрдэнэ.

2.1.1. Үнэт цаас гаргагчийн тайлант хугацааны санхүүгийн мэдээлэл:

2.1.1.1. үнэт цаас гаргагчийн жилийн санхүүгийн тайлан тэнцэл, тодруулга;

2.1.1.2. аудитын үйлчилгээ үзүүлсэн компани нь санхүүгийн тайланд орсон мэдээлэл нь үнэн зөв, олон улсын стандартын дагуу тайлагнасныг баталж, үйлчилгээ үзүүлсэн этгээдтэй сонирхлын зөрчил үүсгээгүй, хараат бусаар ажилласан талаарх баталгаат захидал;

2.1.1.3. үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;

2.1.1.4. үнэт цаас гаргагчийн жилийн санхүүгийн тайлангийн мэдээлэлд хөрөнгө оруулагч болон хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн нөхцөл байдал, төлбөрийн ба хөрвөх чадварыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг агуулна.

2.1.2. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагаас гаргах тайлангийн мэдээлэл: Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон

өөрчлөлт, удирдлагаас өгсөн үнэлгээ, компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг мэдээллийг тусгасан тайланг дараах агуулгын хүрээнд гаргана.

2.1.2.1. Үйл ажиллагааны үр дүнгийн мэдээлэл: тайлант жилд үнэт цаас гаргагчийн орлогод нөлөөлсөн гадаад, дотоод орчны нөлөөллийг тусгасан дүгнэлт, мэдээлэл;

2.1.2.2. Хөрвөх чадварын болон санхүүгийн нөөц, боломжийн мэдээлэл: Үнэт цаас гаргагчийн богино, дунд, урт хугацааны төлбөрийн болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд, үнэт цаас гаргагч өөрийн санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах боломж, шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод санхүүжилтийн эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх дүгнэлт, мэдээлэл;

2.1.2.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл;

2.1.2.4. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх товч мэдээлэл.

2.1.3. **Сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл:** Үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл, дээрх хэлцлийг хийснээр гарах үр дүн, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл;

2.1.4. **Цалин урамшууллын мэдээлэл:** Санхүүгийн жилд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагад олгосон цалин урамшуулал, шагнал, тэдгээрийн эзэмшдэг опцион болон хувьцааны тоо ширхэг, үнэт цаас гаргагчаас баримталдаг нөхөн олговор, урамшуулал, шагналын талаарх баримталдаг бодлого;

2.1.5. **Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл:** Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, хараат, хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын чиг үүрэг, хариуцлага, гишүүдийн нэр, боловсрол, ажлын туршлага, ёс зүйн кодекс, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, мөн төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын ажлын тайланг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын дүгнэлт, гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, мэдээлэл. Үнэт цаас гаргагчаас шаардлагатай тохиолдолд Хорооноос баталсан үнэлгээний аргачлалын дагуу өөрийн компанийн засаглалыг үнэлсэн үнэлгээний тайлан.

2.1.6. **Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл:** Санхүүгийн салбарт болон гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үнэт цаас гаргагч нь гадаад худалдаа болон арилжаанд бий болсон зах зээлийн эрсдэлийг удирдах чиглэлээр гаргасан үүсмэл санхүүгийн болон бусад хэрэгслийн мэдээлэл, зах зээлийн эрсдэлийг тооцдог арга аргачлал, эрсдэлийг удирдах стратегийн талаарх мэдээлэл;

2.1.7. **Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:** Үнэт цаас гаргагчийн тайлант жилдэх эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий, хяналтын багц эзэмшигч гадаад дотоодын иргэн, аж ахуйн нэгжийн нэрс, хувьцааны тоо ширхэг, төвлөрлийн мэдээлэл;

Мөн үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшдэг охин, хараат компанийн мэдээлэл, тайлант хугацаанд Компанийн тухай хуульд заасны дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэн хувьцаа худалдсан хувьцаа эзэмшигчийн тоо, үнийн дүнгийн мэдээлэл;

2.1.8. **Ногдол ашгийн мэдээлэл:** Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого, тухайн жилд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тараах хэлбэр, ногдол ашги хуваарилахгүй тохиолдолд энэ талаарх үндэслэл, өмнөх жилд ногдол ашиг хуваарилсан тохиолдолд түүний тараалтын тайлан, мэдээлэл;

2.1.9. **Нийгмийн хариуцлага:** Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлан, мэдээлэл.

2.2. Үнэт цаас гаргагч нь санхүүгийн жилийн үйл ажиллагааны мэдээллийг дараах маягтын дагуу гаргана. Үүнд:

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа:</i>	<i>2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр</i>
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	<i>“Могойн гол” хувьцаат компани, 1710001002, код-444, Гүйцэтгэх захирал-99119423, Тэргүүн дэд захирал-99906629, ерөнхий инженер-99042168</i>
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	<i>Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК</i>
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	<i>Уул уурхай, нүүрс олборлох үйл ажиллагаа эрхэлдэг</i>
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>	<i>Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газар, Бүртгүүлсэн огноо: 2000 он</i>
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	<i>“Могойн гол” ХК нь нийт 829622 ширхэг энгийн хувьцаатай.</i>
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	<i>Тайланг бэлтгэсэн: Компанийн эдийн засагч Л.Шинэцэцэг, хянасан гүйцэтгэх захирал Б.Батхүү</i>

1. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан. /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргав./

Санхүүгийн байдлын үзүүлэлт:

Орлогын тайлан	2022 оны 4-р улирлын санхүүгийн тайлангаар нийт орлогын дүн 7,045,104.9 мянган төгрөг байна.
Өмчийн өөрчлөлтийн тайлан	2022 оны 4-р улирлын санхүүгийн тайлангаар нийт өмчийн өөрчлөлтийн дүн 5,260,463.0 мянган төгрөг байна.
Мөнгөн гүйлгээний тайлан	2022 оны 4-р улирлын санхүүгийн тайлангаар нийт мөнгөн гүйлгээний дүн 7,587,253.5 мянган төгрөг байна.

1.1.	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>	
	<i>Компанийн 2022 оны жилийн санхүүгийн тайланд Ховсгөл аймаг дахь Торийн аудитын газар, гүйцэтгэгчээр “Нью-баланс аудит” ХХК аудит хийсэн.</i>	
1.2.	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>	
	<i>Аудитын газрын тодорхойлох захидлыг хавсаргав.</i>	
2.	<i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>	
	<i>2022 оны тайлант хугацаанд компанийн үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд дотоод, гадаадын олон хүчин зүйлс нөлөөлсөн бөгөөд тэдгээр хүчин зүйлсийн нөлөөллийг арилгах, даван туулах зорилгоор ТУЗ-өөс шуурхай арга хэмжээ авч, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан компанийн бизнес төлөвлөгөө болон худалдан авах арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан баталж, гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлж ажилласан.</i>	
2.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<i>Борлуулалтын ашигт ажиллагаа= цэвэр ашиг/борлуулалтын орлого 1217179530.92 / 7045104927.16=0.17</i>
2.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт</i>	<i>TXXX=мөнгөн хөрөнгө+авлага /богино хугацаат өр төлбөр (455965933.98+88637636.59)/940661553.35=0.58</i>
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	<i>2022 онд компанийн үйлдвэрлэл болон санхүүгийн үйл ажиллагаанд үзүүлсэн гадаад, дотоод орчны нөлөөлөл маш өндөр байв. Үүнд:</i> <ol style="list-style-type: none"> <i>1. “Ковид-19” цар тахлын үр дагавар 2022 онд үргэлжилж, валютын ханш, түүхий эдийн үнийн огцом өсөлт уурхайн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн.</i> <i>2. Орос, Укрианы дайны нөхцөл байдлаас шалтгаалан уурхайд импортоор худалдан авдаг тэсрэх бодис, дизель түлшний хомсдол үүсэж, улмаар тэдгээр түүхий эдийн үнэ 2 дахин өсөж, үйлдвэрлэлийн зардал үлэмж хэмжээгээр нэмэгдсэн байна.</i>

		Компани эдгээр орчны нөлөөллийг даван туулж, Хөвсгөл, Завхан аймгийг бүхэлд нь эрчим хүчний нүүрсээр ханган ажилласан бөгөөд дотоод, гадаадын 10 гаруй худалдан авагч компанид ондор чанарын коксжих нүүрс нийлүүлж, нэмэлт борлуулалтын орлого бүрдүүлэн ажилласан. Цаашид компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс санаачлан, нүүрсний олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад онцгой анхаарч, нүүрс баяжуулах үйлдвэр байгуулан, шинэ бүтээгдхүүн хөгжүүлэн, коксжих нүүрсний баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөн, 2022-2023 оны бизнес төлөвлөгөөнд тусган, ТУЗ-өөр батлуулан, зохих арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	2022 оны санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн аливаа ажил, гүйлгээ байхгүй.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тус компани нь 2022 оны тайлант хугацаанд банк, бусад банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээл байхгүй болно.
3.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	2022 оны тайлант хугацаанд компанийн үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд дотоод, гадаадын олон хүчин зүйлс нөлөөлсөн бөгөөд тэдгээр хүчин зүйлсийн нөлөөллийг арилгах, даван туулах зорилгоор ТУЗ-өөс шуурхай арга хэмжээ авч, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан компанийн бизнес төлөвлөгөө болон худалдан авах арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт, тодотгол оруулан баталж, гүйцэтгэх удирдлагад хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж өгч ажилласаны үр дүнд компанийн ашигт ажиллагааны түвшин өнгөрсөн оноос өссөн үзүүлэлттэй гарсан.
4.	Цалин урамшуулал, нөхөн олговрын талаарх мэдээлэл	2022 онд ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагад олгосон цалин, урамшууллын хэмжээ 137,453,900.00 төгрөг байна. Тус компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан, мөн мэргэжлээс шалтгаалах өвчны улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан ахмад уурхайчдад олгох нэг удаагийн нөхөн олговрыг ажилласан жил, мэргэжлийн эмнэлэгийн байгууллагын дүгнэлт зэргийг үндэслэн, гүйцэтгэх удирдлагын саналыг харгалзан ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж ирсэн байна. ТУЗ нь гүйцэтгэх удирдлагатай хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажилладаг бөгөөд уг гэрээнд тухайн жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үндсэн

	<p>үзүүлэлт болох уурхайн хөрс хуулах, нүүрс олборлон борлуулах төлөвлөгөө, түүний гүйцэтгэл болон нийт борлуулалтын орлого, зардал, ашигт ажиллагаа зэрэг зорилтот түвшингийн үзүүлэлтүүдийг зааж, гэрээний хавсралтаар баталгаажуулан мөрддөг.</p> <p>Тухайн жилд компани ашигтай ажилласан тохиолдолд санхүүгийн тайлангийн үр дүнгээр гарсан цэвэр ашигаас тооцон 5 хүртэлх хувиар гүйцэтгэх удирдлагад нэг удаагийн урамшуулал олгох бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг.</p> <p>2022 онд гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг ТУЗ-ийн хурлаар авч хэлэлцээд, ТУЗ-тэй байгуулсан гэрээний үүргээ хангалттай биелүүлсэн гэж дүгнэсэн.</p>
5.	<p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p> <p>“Могойн гол”ХК нь Компанийн тухай хууль болон дүрэмд заасны дагуу компанийн засаглал, удирдлагын үйл ажиллагаа нь дараахи хэлбэрээр хэрэгжүүлдэг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. 2. ХЭХурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна гэж дүрэмд заасан. ТУЗ нь 9 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн хурлаас Аудитын, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороог томилдог. 3. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ. <p>ТУЗ-ийн хурлаас гүйцэтгэх захирлыг томилон ажиллуулах бөгөөд гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, түүний хэрэгжилтийг жил тутам дүгнэн ажиллаж байна. Мөн компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны хэм, хэмжээг тогтоож, компанийн бүтэц, зохион байгуулалт, ажиллагсадын орон тоог ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн, баталж мөрдүүлдэг.</p> <p>2022 онд тус компанийн гүйцэтгэх удирдлага нь гүйцэтгэх захирал, уурхайн үйлдвэрлэл, техникийн бодлого хариуцсан тэргүүн дэд захирал, дэд бүтцийн хөгжил, нийгмийн асуудал хариуцсан дэд захиралтайгаар үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.</p>
6.	<p>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</p> <p>Тус компани нь санхүүгийн салбарт болон гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаггүй учраас зах зээлийн эрсдэлийн мэдээлэл гаргаагүй болно.</p>
7.	<p>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</p> <p>Орон нутгийн өмч 423107 ширхэг хувьцаа буюу 51 хувь, иргэн Ж.Батболд 135451 ширхэг хувьцаа буюу 16.3 хувь, ОХУ-ын “Транснефть” компани 124444 ширхэг хувьцаа буюу 15 хувийг эзэмшиж байна. Тус компанийн ТУЗ-ийн хурлаас тогтоосон хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 932 байна.</p>
8.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжисж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</p> <p>2022 онд компани нь аливаа төсөл хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хувьцаа болон бонд гаргах, тэдгээрийг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа явуулаагүй.</p>
9.	<p>Ногдол ашгийн мэдээлэл</p>

	<p>2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгээр нэгж хувьцаанд 600 төгрөгийн ногдол ашиг олгосон бол 2022 оны санхүүгийн тайлангийн үр дүнгээр нэгж хувьцаанд 1182 төгрөгийн ногдол ашиг олгох шийдвэрийг Толоолон удирдах зөвлөлөөс гаргаж, хувьцаа эзэмшигчдэд тараах ажлыг ҮЦТХТ-тэй хамтран зохион байгуулсан байна.</p>
10.	<p>Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл:</p> <p>“Могойн гол”ХК нь тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:</p> <p>1.Тус компанийн уурхайн үйл ажиллагаа нутаг дэвсгэрт нь явагддаг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төвийг дулаанаар хангах үйлчилгээ үзүүлдэг “Уурын зуух”-ны өвлийн улиралд хэрэглэх нийт нүүрсний үнийн дүнгийн 80 хувь, мөн хөрш зэргэлдээ Цагаан-Уул сумын төвийн “Уурын зуух”-ны өвлийн улиралд хэрэглэх нийт нүүрсний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх хямдрал, хөнгөлөлт үзүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх болон орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд нийгмийн тодорхой асуудлыг бодиттойгоор шийдвэрлэж ажилласан. Энэ ажлын хүрээнд Цэцэрлэг сум 58,9 сая төгрөг, Цагаан-Уул сум 30,4 сая төгрөгийн хөнгөлөлт, дэмжлэгт хамрагдсан.</p> <p>2. Мөн Цэцэрлэг сумын төвд оршин суудаг айл, өрхүүдэд нийт 258 тонн түлшний нүүрсийг 20 хувийн үнийн хямдралтай нийлүүлж, 3,3 сая төгрөгийн шууд дэмжлэг үзүүлсэн байна.</p>

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Батаагийн БАТХҮҮ

Овог, нэр: Алтангэрэлийн ЭРДЭНЭБААТАР

Албан тушаал: “Могойн гол” ХК-ийн гүйцэтгэх захирал


Албан тушаал: Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор

Гарын үсэг:

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)



(Тамга/тэмдэг)


1720090001 : 0070605

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо.

Овог нэр: Жигжидсүрэнгийн Батболд

Албан тушаал: “Могойн гол” ХК-ийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:



ГУРАВ. Үнэт цаас гаргагчийн хагас жил болон улирлын тайлангийн мэдээллийн агуулга

3.1. Үнэт цаас гаргагчийн хагас жил болон улирлын тайлан мэдээлэлд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулагчын шийдвэр гаргахад шаардлагатай үнэт цаас гаргагчийн санхүү, үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн шинжтэй мэдээлэл агуулагдах бөгөөд дараах төрөлтэй байна. Үүнд:

3.1.1. Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргасан хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан, тодруулгын мэдээлэл;

3.1.2. Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан;

3.1.3. Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;

3.1.4. Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооноос хагас жил болон улирлын тайланг хэлэлцэж, тайланд тусгасан мэдээлэл үнэн зөв талаарх дүгнэлт;

3.1.5. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний мэдээлэл;

3.1.6. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл;

3.1.7. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцааны талаарх мэдээлэл, үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.

3.2. Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлагналын мэдээллийг дараах маягтын дагуу ирүүлнэ. Үүнд:

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа:</i>	<i>2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр.</i>
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн</i>	<i>“Могойн гол” хувьцаат компани, 1710001002, код-444, Гүйцэтгэх захирал-99119423, Тэргүүн дэд захирал-99906629, ерөнхий инженер-99042168</i>

гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хоронгийн Бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Уул уурхай, нүүрс олборлох үйл ажиллагаа эрхэлдэг
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	“Могойн гол” ХК нь нийт 829622 ширхэг энгийн хувьцаатай.
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайланг бэлтгэсэн: Компанийн эдийн засагч Л.Шинэцэцэг, хянасан гүйцэтгэх захирал Б.Батхүү

1. 2022 оны 4-р улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргав./

Санхүүгийн байдлын үзүүлэлт:

Орлогын тайлан	2022 оны 4-р улирлын санхүүгийн тайлангаар нийт орлогын дүн 7,045,104.9 мянган төгрөг байна.
Өмчийн өөрчлөлтийн тайлан	2022 оны 4-р улирлын санхүүгийн тайлангаар нийт өмчийн өөрчлөлтийн дүн 5,260,463.0 мянган төгрөг байна.
Мөнгөн гүйлгээний тайлан	2022 оны 4-р улирлын санхүүгийн тайлангаар нийт мөнгөн гүйлгээний дүн 7,587,253.5 мянган төгрөг байна.

2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>	
	2022 оны санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооноос өгсөн дүгнэлтийг хавсаргав.	
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>	
	<i>Компанийн 2022 оны үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагааг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгч, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтийг ТУЗ-ийн тогтоолоор баталгаажуулсан.</i>	
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Борлуулалтын ашигт ажиллагаа= цэвэр ашиг/борлуулалтын орлого 1217179530.92 / 7045104927.16=0.17
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт</i>	ТХХХ=мөнгөн хөрөнгө+авлага /богино хугацаат өр төлбөр (455965933.98+88637636.59)/940661553.35=0.58
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт</i>	2022 онд компанийн үйлдвэрлэл болон санхүүгийн үйл ажиллагаанд үзүүлсэн гадаад, дотоод орчны нөлөөлөл өндөр байв. Үүнд: 1.“Ковид-19” цар тахлын үр дагавар 2022 онд үргэлжилж, валютын ханш, түүхий эдийн үнийн огцом өсөлт уурхайн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн.

	цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	<p>2.Орос, Украины дайны нөхцөл байдлаас шалтгаалан уурхайд импорттоор худалдан авдаг тэсрэх бодис, дизель түлшний хомсдол үүсэж, улмаар тэдгээр түүхий эдийн үнэ 2 дахин өсөж, үйлдвэрлэлийн зардал үлэмж хэмжээгээр нэмэгдсэн байна.</p> <p>Компани эдгээр орчны нөлөөллийг даван туулж, Хөвсгөл, Завхан аймгийг бүхэлд нь эрчим хүчний нүүрсээр тасралтгүй ханган ажилласан бөгөөд дотоод, гадаадын 10 гаруй худалдан авагч компанид ондөр чанарын коксжих нүүрс нийлүүлж, нэмэлт борлуулалтын орлого бүрдүүлэн ажилласан. Цаашид компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс санаачлан, нүүрсний олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад онцгой анхаарч, нүүрс баяжуулах үйлдвэр байгуулан, шинэ бүтээгдхүүн хөгжүүлэн, коксжих нүүрсний баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөн, 2022-2023 оны бизнес төлөвлөгөөнд тусган, ТУЗ-өөр батлуулан, зохих арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p>
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
		2022 оны тайлант хугацаанд тус компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй байна.
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжисж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
		2022 онд компани нь аливаа төсөл хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хувьцаа болон бонд гаргах, тэдгээрийг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа явуулаагүй.
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	<p>“Могойн гол”ХК нь Компанийн тухай хууль болон дүрэмд заасны дагуу компанийн засаглал, удирдлагын үйл ажиллагааг дараахи хэлбэрээр хэрэгжүүлдэг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. 2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна гэж дүрэмд заасан. ТУЗ нь 9 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн хурлаас Аудитын, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүнийг томилдог. 3. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ. <p>ТУЗ-ийн хурлаас гүйцэтгэх захирлыг томилон ажиллуулах бөгөөд гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, түүний</p>	

	<p>хэрэгжилтийг жил тутам дүгнэн ажиглаж байна. Мөн компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны хэм, хэмжээг тогтоож, компанийн бүтэц, зохион байгуулалт, ажиллагсадын орон тоог ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн, баталж мөрдүүлдэг.</p> <p>2022 онд тус компанийн гүйцэтгэх удирдлага нь гүйцэтгэх захирал, уурхайн үйлдвэрлэл, техникийн бодлого хариуцсан нэргүүн дэд захирал, дэд бүтцийн хөгжил, нийгмийн асуудал хариуцсан дэд захиралтайгаар үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.</p>
7.	<p>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</p>
	<p>“Могойн гол” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон ТУЗ нь 9 гишүүнтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 51 хувийн хувьцаа эзэмшигчдийн төлөөллөөс Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга Б.Должинсоргодог, аймгийн хуулийн хэлтсийн дарга М.Алтаншагай, аймгийн ИТХ-ийн ажилтан Б.Билэгт-Отгон, бусад хувийн хувьцаа эзэмшигчдийн төлөөллөөс уул уурхайн инженер Ж.Батболд, эдийн засагч Н.Батдорж, уул уурхайн ашиглалтын инженер Л.Батдэлгэр нар ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн, эдийн засагч Д.Болор-Эрдэнэ, уул уурхайн ашиглалт, өрөмдлөг тэсэлгээний технологи чиглэлээр мэргэшсэн, инженер Б.Түмэндэлгэр, уул уурхайн техник, тоног төхөөрөмжийн чиглэлээр мэргэшсэн, инженер Н.Нэргүй нар сонгогдон ажиллаж байна. Мөн ТУЗ-ийн дэргэд Аудитын, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороог тус бүр 5 гишүүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулж, хорооны гишүүдийн гуравны хоёр нь хараат бус гишүүн байна.</p>

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Батаагийн БАТХҮҮ


Овог, нэр: Алтангэрэлийн ЭРДЭНЭБААТАР

Албан тушаал: “Могойн гол” ХК-ийн гүйцэтгэх захирал

Албан тушаал: Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор

Гарын үсэг:

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог нэр: Жигжидеүрэнгийн Батболд

Албан тушаал: “Могойн гол” ХК-ийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:

ДӨРӨВ. Үнэт цаас гаргагчийн тухай бүр мэдээлэх мэдээллийн агуулга

4.1. Үнэт цаас гаргагчаас тухай бүр мэдээлэх мэдээлэл гэдэгт хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчаас шийдвэр гаргахад шаардлагатай компанийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон ажил хэрэг, үйл ажиллагаатай холбоотой цогц мэдээллийг ойлгоно.

4.1.1. Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, гэрээний хугацаа дууссантай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээг байгуулсан огноо, гэрээний нөхцөл, гэрээнд оролцогч талуудын эрх үүрэг, гэрээний нэг талд түүний охин хараат компани оролцсон эсэх талаарх мэдээлэл;

4.1.2. Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээлэл;

4.1.3. Үнэт цаас гаргагч нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцэл;

4.1.4. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын гадуурх бүртгэлтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус эрх үүрэг бий болгосон гэрээ, хэлцэл, гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээ, хэлцлийн хугацаа, үнийн дүн, төлбөрийн нөхцөл, гүйлгээний товч утга, богино болон урт хугацаат түрээсийн гэрээнээс бий болсон эрх үүрэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой мэдээлэл;

4.1.5. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдээс СТОУС-ын дагуу компанийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзэн дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох шийдвэр, шийдвэрийг гаргах болсон нөхцөл, шаардлага, үнэ цэнэ нь буурсан хөрөнгө болон хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хэмжээ эсхүл хязгаарын тооцоолол;

4.1.6. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шалгуурыг хангахгүй болсонтой холбогдуулан бүртгэлийн ангилал бууруулах, эсхүл бүртгэлээс хасагдах мэдэгдэл хүлээн авсан тухай мэдээлэл. Хэрэв үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд үлдэх хүсэлт гаргасан бол уг хүсэлт хүргүүлсэн огноо болон дээрх мэдэгдлийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүртгэлтэй хугацаанд биелүүлсэн болон хангаж чадаагүй гэрээгээр хүлээсэн үүргийн талаарх мэдээлэл;

4.1.7. Үнэт цаас гаргагчийн тайланд аудит хийж буй хараат бус нягтлан бодогч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан зэрэг шалтгаанаар өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар мэдэгдэх бөгөөд нягтлан бодогчоос үнэт цаас гаргагчийн дээрх мэдээлэлтэй санал нийлж буй эсэх талаар мэдэгдлийг хавсаргана, эсхүл шинэ хараат бус нягтлан бодогч ажилд орсон бол ажилд томилсон шийдвэр, шинэ нягтлан бодогчийн үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлантай холбоотой гаргасан санал, дүгнэлт, зөвлөгөө;

4.1.8. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдээс компанийн өмнөх жилүүд болон улирлын санхүүгийн тайланд алдаа гарсан гэж үзсэн бол алдаатай санхүүгийн тайлангууд, алдаа гарсан гэж үзэх үндэслэл, нөхцөл, компанийн аудитын хороо, эсхүл эрх бүхий албан тушаалтан энэ талаар хараат бус нягтлан бодогчтой хэлэлцсэн эсэх талаар мэдээлэл, хараат

бус нягтлан бодогчоос үнэт цаас гаргагчид санхүүгийн тайлангийн алдаатай байдлын талаар мэдэгдсэн бол нягтлан бодогчоос өгсөн мэдэгдлийн огноо, товч агуулгыг талаарх мэдээлэл.

4.1.9. Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл: Компанийн хяналтын хувьцааг худалдах болон шилжүүлэхээр хийгдсэн хэлцлийн хугацаа, товч танилцуулга, зорилго, төлбөр төлөх хэлбэр, төлбөрийн зарцуулалт, худалдан авагчийн товч танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, өмнөх хувьцаа эзэмшигчдийн хувь хэмжээний бууралтын талаарх мэдээлэл;

4.1.10. Компанийн эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, чөлөөлөхтэй холбоотой мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, огцруулж, нөхөн томилох, эсвэл татгалзсан хурлын тэмдэглэл, шийдвэрийн агуулга, огноо, төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагыг томилж, чөлөөлсөн талаарх мэдээлэл;

4.1.11. **Үнэт цаас гаргагчийн дүрэмд орсон өөрчлөлт:** Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталсан дүрмийн өөрчлөлтийг Хороо, төрийн холбогдох байгууллагад бүртгүүлсэн огноо, дугаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, эцэслэсэн дүрэм;

4.1.12. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэр, арга хэмжээний талаарх мэдээлэл;

4.1.13. Компанийн ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, зарим хэсгийг түр түдгэлзүүлсэн талаарх мэдээлэл;

4.1.14. Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулсан, үндсэн болон шинэ бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрх хүчингүй болсон эсхүл цуцлагдсан талаарх мэдээлэл;

4.1.15. Оноосон нэр, үндсэн захиргаа, оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн талаар, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, эсхүл татан буулгах талаарх мэдээлэл;

4.1.16. Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон талаарх мэдээлэл;

4.1.17. Үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болох, үнэт цаас гаргагчийг татан буулгах чиглэлээр гаргасан шийдвэр.

4.2. Тухай бүр мэдээлэх мэдээллийг дараах маягтын дагуу ирүүлнэ.

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>

Тайлагнах хугацаа: 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр/	2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас хойш 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуртэлх хугацааны тайлан, мэдээлэл
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Могойн гол” хувьцаат компани, 1710001002, код-444, Гүйцэтгэх захирал-99119423, Тэргүүн дэд захирал-99906629, еронхий инженер-99042168
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хоронгийн Биржс ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Уул уурхай, нүүрс олборлох үйл ажиллагаа эрхэлдэг
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	“Могойн гол” ХК нь нийт 829622 ширхэг энгийн хувьцаатай.
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Мэдээллийг бэлтгэсэн: “Могойн гол” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Батхүү, хянасан ТУЗ-ийн дарга Ж.Батболд
1.	Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гэрээ, хэлцлийн талаар
	2022 онд компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гэрээ, хэлцэл хийгдээгүй.
2.	Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанид аливаа захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн эсэх талаар
	2022 онд компанийн эрх бүхий албан тушаалтнуудад аливаа захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгээгүй байна.
3.	Үнэт цаас гаргагч нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан гэрээ, хэлцлийн талаар
	2022 онд компанийн үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, банк санхүүгийн байгууллагад барьцаалах болон хяналтын багц худалдан авах гэрээ, хэлцэл хийгдээгүй байна.
4.	Үнэт цаас гаргагчийн балансын гадуурх бүртгэлийн талаар
	2022 онд компанийн аливаа эд хөрөнгөнд балансын гадуурх бүртгэл хийгдээгүй.
5.	Хөрөнгийн дахин үнэлгээний талаар
	2022 онд компанийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй болно.
6.	Үнэт цаас гаргагч арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүргийн хэрэгжилтийн талаар
	2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдсон ТУЗ-ийн гишүүдийн талаар нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хооронд ойлгоцлын зөрүүтэй байдал үүссэний улмаас маргаан гарч, ТУЗ-ийн хурал 3 удаа хойшлогдсон бөгөөд энэ тухай СЗХ-ны Хяналт, шалгалтын газраас анхааруулга ирүүлж, түүний биелэлтийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл хангаж ажилласан.
7.	Үнэт цаас гаргагчийн хараат бус нягтлан бодогчийн өөрчлөлтийн талаар

	2022 онд компанийн хараат бус нягтлан бодогч өөрчлөгдсөн тохиолдол гараагүй.
8.	Өмнөх жилүүд болон улирлын санхүүгийн тайланд алдаа гарсан бол энэ талаар Компанийн санхүүгийн тайланд өмнөх жилүүдэд болон 2022 оны жилийн эцсийн байдлаар аливаа алдаа гараагүй байна.
9.	Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл 2022 онд “Могойн гол” хувьцаат компанийн хувьцааны хяналтын багцыг бусад этгээд худалдан аваагүй байна.
10.	Компанийн эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл 2021 онд компанийн гүйцэтгэх захирал Б.Хаашбат нь аймгийн ИТХ-д нэр дэвшихтэй холбоотойгоор үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж, чөлөөлөгдсөн бөгөөд 2022 оны 3 дүгээр сарын ТУЗ-ийн хурлаас гүйцэтгэх захирлаар Б.Батхүүг томилсон. 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдсон ТУЗ-ийн гишүүдийн анхдугаар хуралдаан 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд тус хуралдаанаас ТУЗ-ийн даргаар Ж.Батболд сонгогдон ажиллаж байна.
11.	Үнэт цаас гаргагчийн дүрэмд орсон өөрчлөлтийн талаар 2022 онд “Могойн гол” ХК-ийн дүрэмд аливаа өөрчлөлт ороогүй болно.
12.	Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээний талаар Тус компанид ажиллаж байсан гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд “Могойн гол” ХК-ийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авах аливаа арга хэмжээ явагдаагүй болно.
13.	Компанийн ёс зүйн дүрэмд орсон өөрчлөлтийн талаар 2022 онд компанийн ёс зүйн дүрэмд аливаа өөрчлөлт ороогүй байна.
14.	Шинэ техник, технологи нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрхийн талаар 2022 онд тус компани нь уурхайн олборлох үйл ажиллагааг тасралтгүй хянах видео хяналтын систем, нүүрс борлуулах үйл ажиллагааны иж бүрэн программ хангамж зэрэг орчин үеийн шинэ техник, технологи нэвтрүүлсэн бөгөөд нэмэлт шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл аваагүй байна.
15.	Оноосон нэр, хаяг байршлын өөрчлөлт, салбар, төлөөлөгчийн газрын талаар

	2022 онд компанийн оноосон нэр, хаяг байршил өөрчлөгдөөгүй бөгөөд Улаанбаатар хот, бусад аймгуудад салбар, төлөөлөгчийн газар байгуулах аливаа шийдвэрийг ТУЗ-өөс гаргаагүй байна.
16.	Үйл ажиллагааны чиглэл, түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон эсэх талаар
	2022 онд компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөөгүй бөгөөд үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар зогсох тохиолдол гараагүй байна.
17.	Төлбөрийн чадваргүй болох, үнэт цаас гаргагчийг татан буулгах шийдвэрийн талаар
	2022 онд компанийн ТУЗ болон бусад эрх бүхий байгууллагаас тус компани нь санхүүгийн хувьд төлбөрийн чадваргүй болох, татан буулгах чиглэлээр аливаа шийдвэр гараагүй болно.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг,
огноо: 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Овог, нэр: Багаагийн БАТХҮҮ


Овог, нэр: Алтангэрэлийн ЭРДЭНЭБААТАР

Албан тушаал: “Могойн гол” ХК-ийн
гүйцэтгэх захирал

Албан тушаал: Хөвсгөл аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор

Гарын үсэг:

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо.

Овог нэр: Жигжидсүрэнгийн Батболд

Албан тушаал: “Могойн гол” ХК-ийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:

**“Могойн гол” ХК-ийн 2022 оны үйлдвэрлэл,
санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн хавсралт:**

**Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас “Могойн гол” ХК-ийн хувьцаа
эзэмшигчдэд хандан хүргүүлсэн аудитын дүгнэлт, зөвлөмж**



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АУДИТ-ын байр: А корпус: 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг: 67120
Утас/факс: 7038 3793, Цэжигн шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цэжигн хуудас: www.audit.mn

2023.03.24 № 01/283
танай _____ -ны № _____ -т

МОГОЙН ГОЛ ХК ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЭД

Зөвлөмж хүргүүлэх тухай

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрх, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны цаглаварт хугацаанд Могойн гол ХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийсэн. Санхүүгийн тайлангийн аудитыг аудитын олон улсын стандарт, холбогдох хууль, журам, заавар аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн.

Аудитаар илэрсэн удирдлагын үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 193.6 сая төгрөгийн алдааг залруулж, 40.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 193.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, нягтлан бодох бүртгэл, хөрөнгийн зарцуулалттай холбоотой 419.1 сая төгрөг, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,583.2 сая төгрөгийн зөрчилд дахин давтахгүй байх зөрчлийг арилгаж ажиллах зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Иймд тус компанийн удирдах дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хуралд дараах асуудлуудад анхаарч ажиллах шаардлагатай болсныг зөвлөж байна. Үүнд:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг холбогдох хууль журмын хүрээнд байгуулан ажиллуулах
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэр, түүний хэрэгжилтийг хянаж ажиллах
3. Могойн гол ХК-ийн ашигт ажиллагааг сайжруулж, үр ашгийг Хөвсгөл аймгийн нийт ард иргэдэд тэгш хүртээмжтэй байхаар төлөвлөн ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахгүй бол Могойн гол ХК-ийн үйл ажиллагаа доголдож, тус компанийн удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаанд ихээхэн хохирол учирч болзошгүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЗБААТАР

